



ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ᠳᠣᠷᠨᠣᠭᠣᠪᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠨᠢᠶᠭᠦᠮ, ᠡᠳᠢᠶᠢᠨ ᠵᠠᠰᠭᠢᠨ
ᠲᠠᠨᠢᠯᠴᠠᠭᠤᠯᠠᠭ᠎ᠠ

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2020/10



Мэдээллийн нэгдсэн лавлах: WWW.1212.MN

ГАРЧИГ

Товч танилцуулга.....	1-14
Нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд.....	15
Нэг. Эрүүл мэнд.....	16-17
Хоёр. Хөдөлмөр эрхлэлт	18-20
Гурав. Нийгмийн даатгал, халамж.....	21-24
Дөрөв. Гэмт хэрэг.....	25-26
Тав. Мөнгө,зээл	27
Зургаа. Төсөв, санхүү	28-29
Долоо. Үнэ.....	30-33
Найм. Хөдөө аж ахуй	34-36
Ес. Аж үйлдвэр.....	37-41
Арав. Байгаль орчин	42

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

(2020 оны 10 дугаар сарын байдлаар)

Нэг. Нийгмийн үзүүлэлт




1.1 Хүн ам

Дорноговь аймгийн хэмжээнд 2020 оны 10 сард 1203 эх амаржиж, 1212 хүүхэд шинээр мэндэлж, 283 хүн нас барсан байна. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 107(9.8%)-оор, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 112(10.2%)-аар тус тус өсч, нас барсан хүний тоо өмнөх оны мөн үеэс 45(13.7%)-аар буурсан байна.

Хүн амын цэвэр өсөлт 929 болж 2019 оны мөн үеийнхээс 157(20.3%)-оор өссөн байна. 1000 хүнд ногдох төрөлт 17.2, нас баралт 4.0 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 0.9 пунктээр өсч, нас баралт өмнөх оны мөн үеэс 0.7 пунктээр буурсан байна.

Зураг. Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2017-2020 оны 10 сард



Он гарсаар нялхсын эндэгдэл 12 байгаа нь өмнөх оны мөн үеэс 71.4 хувиар өсчээ.



1.2 Эрүүл мэнд


2020 оны эхний 10 сарын байдлаар 341.5 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 1.4 хувиар, 14.5 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 3.6 хувиар тус тус өсч, 9.5 мянган хүн урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 16.7 хувиар буурчээ.

2020 оны эхний 10 сард 1438 эх жирэмсний хяналтанд орсны 90.1 хувь буюу 1296 эх жирэмсний эхний 3-н сард хяналтанд хамрагджээ. Жирэмсний хяналтанд хугацаандаа орсон эхийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 1.1 пунктээр өссөн байна.

Түргэн тусламжийн дуудлага 16.1 мянган удаа гарсны 2.7 мянга буюу 16.8 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал алсын дуудлага өмнөх оны мөн үеэс 8.0 хувиар өсч, нийт түргэн тусламжийн дуудлага өмнөх оны мөн үеэс 0.6 хувиар буурсан байна.

Он гарсаар ослын улмаас 2545 хүн бэртэж, 50 иргэний амь нас энджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэртэж гэмтсэн хүний тоо 305(10.7%)-аар, нас барсан хүний тоо 24(32.4%)-өөр тус тус буурсан.

Зураг. Нас баралт, өвчний шалтгаанаар, хувь. 2020 оны 10 сард



Нас баралтыг өвчний шалтгаанаар авч үзэхэд бусад төрлийн өвчин 45.9 хувийг, цусны эргэлтийн тогтолцооны өвчин 18.4 хувь, хавдар 17.3 хувь, осол, гэмтэл хордлого гадны шалтгаант үхэл өвчин 13.8 хувь, хоол шингээх эрхтний өвчин 4.6 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт өвчний 710 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 155-аар буюу 17.9 хувиар буурчээ. Халдварт өвчний тохиолдол буурахад вирус гепатит 50.0 хувиар, трихоминиаз 43.8 хувиар, тэмбүү 38.3 хувиар, заг хүйтэн 27.9 хувиар, сүрьеэ 11.4 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.




1.3 Бүртгэлтэй ажилгүй иргэн

Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2020 оны 10 сарын эцэст 268 болсны 176 (65.7%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 92 (34.3%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 267(49.7%) хүнээр, өмнөх сараас 52(16.2%) хүнээр тус тус буурчээ.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн боловсролын түвшинг харахад 146(54.5%) нь бүрэн дунд, 78(29.1%) нь дээд, 21(7.8%) нь техник мэргэжлийн, 10(3.7%) нь тусгай дунд, 8(3.0%) нь бүрэн бус дунд, 1(0.4%) магистр, докторын боловсролтой иргэд эзэлж байна.

Зураг. Ажилгүй иргэдийн тоо, боловсролоор, хувиар, 2020 оны 10 сарын эцэст




Хөдөлмөрийн хэлтэст 2020 оны эхний 10 сарын байдлаар 1 075 иргэн шинэ ажлын байранд орж, бүртгэлтэй байсан 87 иргэн ажилд зуучлагдан орж, өмнөх сарын бүртгэлээс 158 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар хасагдсан байна.



1.4 Нийгмийн даатгал, халамж


Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2020 оны 10 сарын байдлаар 33437.9 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1092.0 (3.4%) сая төгрөгөөр өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 2020 оны 10 сард өмнөх оны мөн үеэс 1092.0 сая төгрөгөөр өсөхөд эрүүл мэндийн даатгалын сан 1520.2 сая төгрөгөөр, тэтгэврийн даатгалын сан 1177.0 сая төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого сангийн төрлөөр /сая.төг/ 2020 оны 10 сард



Нийгмийн даатгалын сангийн зарлага 49452.9 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 7775.9 (18.7%) сая.төгрөгөөр өссөн байна. Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 37154.7(75.1%) сая.төг, эрүүл мэндийн даатгалын сангаас 5848.9(11.8%) сая.төг, тэтгэмжийн даатгалын сангаас 2927.6(5.9%) сая.төг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 2242.6(4.5%) сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 1279.2(2.6%) сая төгрөгийг зарцуулжээ.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сая төг



Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 2020 оны 10 сард нийгмийн халамжийн сангаас 23448 иргэнд 7337.8 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Өмнөх онтой харьцуулахад халамж авсан иргэд 1132(4.6%)-аар буурч, олгосон тэтгэвэр тэтгэмж 329.7(4.7%) сая төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2020 оны 10 сард 1399 хүн хамрагдсан нь өмнөх оноос 21(1.5%)-аар буурч, олгосон тэтгэвэрийн хэмжээ 974.1(45.5%) сая төгрөгөөр өсчээ.


Нийгмийн нөхцөлт мөнгөн тусламжийг 1169 иргэнд 927.5 сая төгрөг, онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг 1083 иргэнд 762.2 сая төгрөг тус тус олгож, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургахад 8371 иргэнийг хамруулж, 1116.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Бусад төрлийн халамжийн үйлчилгээнд 11426 иргэн хамрагдаж, 1417.8 сая төгрөгийг олгожээ.

Зураг. Хүний тоо



Зураг. Олгосон тэтгэвэр, тэтгэмж /сая. төг/





1.5 Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр 2020 оны эхний 10 сарын байдлаар 340 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 103 хүн гэмтэж, 13 хүн нас барсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 157 (31.6%)-аар, гэмтсэн хүний тоо 81 (44.1%) -ээр, нас барсан хүний тоо 17 (56.7%)-оор тус тус буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 3(17.6%)-аар, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг 2-оор, нийтийн ашиг сонирхлын эсрэг 1(20.0%)-ээр, бусад төрлийн эсрэг гэмт хэрэг 1(33.3%)-ээр тус тус өсч, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг 70(47.0%)-аар, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 17(9.0%)-аар, улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг 17(58.6%) -оор, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 15(37.5%)-аар, хүн амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 14(66.7%)-аар, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 13(59.1)-аар, авилгын гэмт хэрэг 4(66.7%)-өөр тус тус буурч, үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, цэргийн албаны эсрэг гэмт хэрэг, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.


Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сараар



Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 50.3 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 23.2 хувийг хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, 7.4 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 5.9 хувийг хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, 3.5 хувийг улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг, 2.9 хувийг хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 2.1 хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, 4.27 хувийг бусад төрлийн гэмт хэргүүд эзэлж байна. Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 69 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 74(51.7%)-өөр буурсан байна.

Гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс Айраг, Дэлгэрэх, Мандах, Өргөн, Сайхандулаан сумдад нэмэгдэж, Алтанширээ, Улаанбадрах сумдад өмнө онтой адил, бусад сумдад гэмт хэргийн тоо буурсан байна.


Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сумаар



Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 1993.9 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 320.4(13.8%) сая төгрөгөөр буурсан байна. Учирсан хохирлын 600.8(62.7%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Нийт гэмт хэргийн 82(29.5%) нь гэр орон сууцандаа, 45(16.2%) нь согтуугаар, 36(12.9%) нь гудамж олон нийтийн газарт, 28(10.1%) бүлэглэн, 30(10.8%) хувийг эмэгтэй хүн болон хүүхэд оролцон, 82(29.5%) нь шөнийн цагаар /22-06 цагт/ үйлдсэн байна. Тайлант хугацаанд нийт 713 хүн саатуулагдаж, 162 хүн баривчлагджээ.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэрэг үйлдэгдсэн цагаар 2020 оны 10 сард




Хоёр. Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт




2.1 Мөнгө, банк

Монгол банкны мэдээгээр арилжааны банкуудын зээлдэгчийн тоо 36.8 мянга болж өмнөх оноос 1.6(4.5%) мянган хүнээр өсч, нийт хадгаламжийн данс эзэмшигчийн тоо 76.9 мянга болж өмнөх оны мөн үеээс 7.7 хувиар өссөн байна.

Зураг. Хадгаламжийн үлдэгдэл, зээлийн өрийн үлдэгдэл, 2019-2020 он, сая.төг



Зураг. Хадгаламж эзэмшигч, зээлдэгчийн тоо, 2019- 2020 он, мян.хүн




Нийт хадгаламжийн үлдэгдэл 145.8 тэрбум төгрөг болж нэг хадгаламж эзэмшигчид дунджаар 1896.5 мянган төгрөг, аймгийн нэг хүнд дундажаар 2095.4 мянган төгрөгийн хадгаламж ногдож байна. Хадгаламжийн үлдэгдлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 29.6(25.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна.


Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл сарын эцэст 6.3 тэр бум төгрөг болж, өмнөх сараас 0.3(4.9%) тэрбум төгрөгөөр өсж, өмнөх оны мөн үеэс 1.5(32.9%) тэр бум төгрөгөөр өсчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 2.4 хувийг эзэлж, өмнөх сараас 0.1 пунктээр буурч, өмнөх оны мөн үеэс 0.7 пунктээр өсчээ.

Чанаргүй зээл сарын эцэст 13.2 тэр бум төгрөг болж өмнөх сараас 214.3(1.6%) сая төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 5817.9(78.7%) сая төгрөгөөр тус тус өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.9 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 2.3 пунктээр өссөн байна.

Зураг. Зээл төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2020.10 сард




Зураг. Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр, 2020.10 сард



2.2 Төсөв, санхүү

2020 оны 10 дугаар сарын байдлаар орон нутгийн төсөвт 28872.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 72.7 хувь байна. Өмнөх оны мөн үетэй төсвийн орлогын дүнг харьцуулахад 31.8 хувиар буурсан байна / 2020 оны орон нутгийн төсвийн орлогод улсын төсөв, орон нутгийн төсөв хоорондын шилжүүлсэн орлогын дүн тусгагдаагүй/. Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 76.7 хувийг татварын, 23.3 хувийг татварын бус орлого бүрдүүлсэн байна.

Зураг. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүтэц, хувиар, 2020 оны 10 сард



Улсын нэгдсэн төсөвт ААНБ-ын орлогын албан татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, ашигт малтмал нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр, өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөр, ус бохирдуулсны төлбөр нийт 6711.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын дүнг өмнөх оны мөн үеэс 10.9 хувь буюу 821.7 сая.төг-өөр буурч, төлөвлөгөөнөөс 6.9 хувь буюу 431.4 сая.төг-өөр давуулан биелүүлсэн байна.



2.3 Үнэ

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.


Хэрэглээний үнийн индекс 2020 оны 10 дугаар сарыг өмнөх сартай харьцуулахад 0.0 хувь, өмнөх оны мөн үеэс 2.5 хувиар тус тус өсчээ.

Ерөнхий индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.5 хувиар өсөхөд: хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 5.6 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлэг 1.1 хувь, хувцас бөс бараа, гутлын бүлэг 7.4 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 0.2 хувь, гэр ахуйн тавилгын бүлэг 5.8 хувь, эм тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 2.2 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлэг 0.1 хувь, амралт чөлөөт цаг соёлын барааны бүлэг 0.1 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний бүлэг 6.9 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2020 оны 10 дугаар сарын өөрчлөлт, бүлгээр, хувиар (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2019-2020 оны үнийн өөрчлөлт, сар бүрээр (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2016 -2020 оны 10 дугаар сар (өмнөх оны 12-р сар=100)



Гурав. Эдийн засгийн статистикийн үзүүлэлт




3.1 Хөдөө аж ахуй

Аймгийн хэмжээнд 2019 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 1010.6 мянган хээлтэгч малын 737.8 мянга (73.0%) нь 2020 оны эхний 10 сард төллөсөн байна. Эм хонины 80.4 хувь, эм ямааны 69.5 хувь, ингэний 47.5 хувь, үнээний 62.7 хувь, гүүний 54.4 хувь нь төллөжээ.

Гарсан төлийн 99.6 хувь буюу 739.9 мянган төл бойжиж байна. Бойжуулсан төл өмнөх оны мөн үеэс 38.7 (6.0%) мянгаар илүү байна. Дэлгэрэх суманд 78.6 мянга, Айраг суманд 67.7 мянга, Даланжаргалан суманд 67.0 мянга, Хатанбулаг суманд 65.1 мянган, Иххэт суманд 60.5 мянган төл тус тус бойжсон нь нийт бойжсон төлийн 45.8 хувийг эзэлж байна.

Том малын зүй бус хорогдол 2020 оны эхний 10 сард аймгийн хэмжээнд 4776 болж, өмнөх оны мөн үеэс 236 (95.1%) толгойгоор буурсан байна. Нийт хорогдсон малын 47.5 хувийг ямаа, 49.0 хувийг хонь эзэлж байна.

Зураг. Том малын зүй бусын хорогдол, жил бүрийн 10 сард



Малын зах зээлийн дундаж үнийн мэдээгээр нас гүйцсэн ат Хатанбулаг суманд хамгийн их буюу 1500.0 мянган төгрөг, Алтанширээ, Замын-Үүд, Өргөн, Мандах, Эрдэнэ сумдад хамгийн бага буюу 1000.0 мянган төгрөг, соёолон үрээ Алтанширээ, Иххэт суманд их буюу 1000.0 мянган төгрөг, Мандах суманд хамгийн бага буюу 680.0 мянган төгрөг, хязаалан гуна Алтанширээ суманд хамгийн их буюу 1600.0 мянган төгрөг, Мандах суманд хамгийн бага буюу 900.0 мянган төгрөг байна. Нас гүйцсэн эр хонины дундаж үнэ Мандах суманд хамгийн их буюу 220.0 мянган төгрөг, Өргөн суманд хамгийн бага буюу 110.0 мянган төгрөг, нас гүйцсэн эр ямааны дундаж үнэ Эрдэнэ суманд хамгийн их буюу 180.0 мянган төгрөг, Өргөн суманд хамгийн бага буюу 90.0 мянган төгрөг байна.

2020 онд 17.2 га талбайд төмс, 44.1 га-д хүнсний ногоо тариалж, 87.0 тн төмс, 187.8 тн хүнсний ногоо хураан авлаа. Өмнөх оныхоос хураан авсан төмс 4.3 тн-оор нэмэгдэж, хүнсний ногоо 20.0 тн-оор буурсан байна. 1 га-аас 4.5 тонн төмс, хүнсний ногоо хураан авсан нь 2019 оноос 0.3 тн-оор буурсан.



3.2 Аж үйлдвэр

Оны эхний 10 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарт 158.1 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 239.3 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлууллаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 9.6 хувиар, борлуулалт 15.0 хувиар тус тус буурсан байна.

2020 оны 10 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 9.6 хувиар буурахад уул, уурхай олборлох салбарын үйлдвэрлэлт өмнөх оноос 38242.4 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 3.9 хувийг төрийн, 96.1 хувийг хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэжээ.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 3.9 хувь, компани 95.6 хувь, өрхийн аж ахуй 0.5 хувийг тус тус эзэлж байна.

Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дулаан 17.2 мян.ккал-аар, талх 97.0 тонноор, бялуу 2.6 тонноор, хиам 4.8 тонноор, сүүн бүтээгдэхүүн 3.4



мян.литрээр, хэрчсэн гурил 33.2 мян.тн-оор, шохой 2250 тонноор, цемент 119.9 мян.тонноор, модон эдлэл 14171.5 мян.төгрөгөөр, хайрга 1.1 мян.м³-аар тус тус илүү үйлдвэрлэгджээ.

Дөрөв. Байгаль орчны статистикийн үзүүлэлт



4.1 Байгаль орчин

Цаг уур

Температур: 10-р сарын дундаж агаарын температур 3.0...5.8 градус дулаан, агаарын хамгийн их температур өдөртөө нийт сумдад 17...20 градус, агаарын хамгийн бага температур шөнөдөө 6-11 градус хүйтэн байв. Агаарын дундаж температурыг олон жилийн дундаж /ОЖД/-тай харьцуулахад: Сайншанд, Замын-Үүд, Мандах, Хөвсгөл, Өргөн сумдад олон жилийн дундажаас 1.1...2.3 градусаар хүйтэн, Иххэт сум -1.1 градусаар дулаан, бусад сумдад ОЖД-ийн орчим байлаа. Хөрсний гадарга дээр шөнөдөө - 8...-13 градус хүйтэн, өдөртөө нийт сумдад 27...36 градус дулаан байв.

Хур тунадас: Сарын нийлбэр хур тунадас Сайншанд суманд 4.7мм, Мандах суманд 1.0мм, Хөвсгөл суманд 0.0мм, Дэлгэрэх сум 5.8мм, Улаан-Уул суманд 1.3мм, Алтанширээ суманд 4.0мм, Өргөн суманд 7.6мм, Сайхандулаан суманд 3.2мм, Иххэт суманд 4.4мм, Замын-Үүд суманд 0.3мм, Улаанбадрах суманд 0.0мм бороо нойтон цас орсон байна. Сарын нийлбэр хур тунадсыг олон жилийн дундажтай харьцуулахад Сайншанд, Сайхандулаан сумдад олон жилийн дундажийн орчим, Замын-Үүд, Мандах, Хөвсгөл, Улаан-Уул, Айраг, Улаанбадрах сумдад олон жилийн дундажаас бага, бусад сумд олон жилийн дундажаас ахиу байлаа.

Салхи: Энэ сард салхины хамгийн их хурд Айраг, Алтанширээ, Иххэт сумдаас бусад сумдын нутгаар салхи секундэд 16-30 метр хүрч цаг агаарын аюултай үзэгдэл болсон байна. Айраг, Алтанширээ, Иххэт сумдын нугаар 12-14м/с байна. 10м/с-ээс дээш салхитай 7...18 өдөр байлаа.

Бэлчээрийн ургамал: 10 дугаар сарын 31-ний байдлаар бэлчээрийн ургамлын дундаж өндөр 4-11 см, нийт сумдын нутгаар бэлчээрийн ургамал шарлаж хаталт хагдралтын үе шат ажиглагдсан байна.

МАН-н үйлдвэрлэлд: Цаг агаарын нөхцлөөс болж малын бэлчээрлэлт саатсан тохиолдол гараагүй. Малчид өвөлжөөндөө бууж байна. Малын усан хангамж ихэнх нутгаар дунд зэрэг байлаа.



ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ
(2020 ОНЫ 10 ДУГААР САРЫН БАЙДЛААР)

I. Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд

	Хэмжих нэгж	2017	2018	2019	2020	2020 2019
1. Бэлэн хүн ам, мян.хүн *	МЯНГАН хүн	68.2	68.5	70.0	70.6	100.9
- Төрсөн хүүхдийн тоо**	тоо	1205	1078	1139	1212	106.4
- Нас барсан хүний тоо - бодит тоогоор**	тоо	304	289	330	283	85.8
- Хүн амын цэвэр өсөлт - бодит тоогоор	тоо	901	789	809	929	114.8
- Нялхасын эндэгдэл - бодит тоогоор	тоо	6	13	7	12	171.4
- 1000 хүүхдэд ноогдох	тоо	5.0	12.1	6.1	9.9	161.1
2. Ажилгүй иргэдийн тоо - бүгд	тоо	1 705	734	533	268	50.3
- Үүнээс эмэгтэй	тоо	841	337	258	152	58.9
- Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүй иргэдийн тоо	тоо	374	153	115	62	54.5
3. Шинээр бий болсон ажлын байр-бүгд	тоо	302	213	325	483	148.6
Үүнээс: Байнгын ажлын байр	тоо	302	87	200	182	91.0
Улирлын чанартай ажлын байр	тоо	0	126	125	41	32.8
Түр ажлын байр		0	0	0	260	0.0
4. Халдварт өвчний гаралт - бодит тоогоор	тоо	609	587	865	710	82.1
- 10000 хүнд ногдох	тоо	78	86	99	101	101.5
5. Гэмт хэргийн гаралт - бодит тоогоор	тоо	589	431	497	340	68.4
- 10000 хүнд ногдох ***	тоо	104	82	88	77	86.7
6.Бойжиж буй төл	толгой	586705	599281	701158	739928	105.5
- Унага	толгой	21649	21919	24267	26557	109.4
- Тугал	толгой	16615	18153	18366	22972	125.1
- Ботго	толгой	6668	6835	7195	8418	117.0
- Хурга	толгой	286903	294822	345708	364341	105.4
- Ишиг	толгой	254870	257552	305622	317640	103.9
7. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая төгрөг	131424.1	185294.9	174855.0	158056.2	90.4
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая төгрөг	267188.4	267966.2	281393.6	176001.5	62.5

* - 2017,2018,2019 оны жилийн эцэст

** -Төрөлт, нас баралтыг ЭМГ-ын мэдээнээс авав.

*** - 18 - аас дээш насны 10000 хүнд ногдохоор тооцов.



НЭГ. ЭРҮҮЛ МЭНД

1.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ

	Хэмжих нэгж	2019 I-X	2020 I-X	Өсөлт	
		тоо		хувь	
1. Амбулаторийн үзлэг	мян.хүн	336.9	341.5	4.6	101.4
2. Ор хоног	мян.хүн	100.0	101.1	1.1	101.1
3. Урьдчилан сэргийлэх тарилга	мян.хүн	11.4	9.5	-1.9	83.3
4. Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	14.0	14.5	0.5	103.6
5. Түргэн тусламжын дуудлага	мян.хүн	16.2	16.1	-0.1	99.4
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	2.5	2.7	0.2	108.0
6. Осол гэмтлийн өвчлөл	хүн	2850	2545	-305	89.3
Үүнээс: нас баралт	хүн	74	50	-24	67.6
7. Шинээр хяналтанд авсан жирэмсэн эх	хүн	1537	1438	-99	93.6
Үүнээс: эхний 3 сартайн хяналт	хүн	1369	1296	-73	94.7
8. Амаржсан эх	хүн	1096	1203	107	109.8
Үүнээс: нас баралт	хүн	0	1	1	0.0
9. 1-5 хүртэл насны эндсэн хүүхэд	хүн	6	2	-4	33.3
10. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүн	7	12	5	171.4

1.2. ТӨРӨЛТ, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар, жил бүрийн 10 сард

Сумын нэр	Амаржсан эх	Эхийн эндэгдэл	Амьд төрсөн хүүхэд	1	1-5
				хүртэл насанд аа эндсэн хүүхэд	хүртэл насны эндсэн хүүхэд
тоо					
Дүн	1203	1	1212	12	1
Айраг	1		1		
Алтанширээ	1		1		
Даланжаргалан	1		1		
Дэлгэрэх					
Иххэт					
Мандах	1		1		1
Өргөн	1		1		
Сайхандулаан					
Улаанбадрах					
Хатанбулаг	1		1		
Хөвсгөл	2		2		
Эрдэнэ	2		2	1	
Сайншанд	942	1	952	9	
Замын - Үүд	251		250	2	

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар



1.3. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, төрлөөр, жил бүрийн 10 сард

Үзүүлэлт	2019 I-X	2020 I-X	Өсөлт	
	тоо	тоо	тоо	хувь
Халдварт өвчний гаралт-Бүгд	865	710	-155	82.1
Вируст гепатит	6	3	-3	50.0
Сүрьеэ	70	62	-8	88.6
Тэмбүү	167	103	-64	61.7
Заг хүйтэн	269	194	-75	72.1
Трихоминиаз	144	81	-63	56.3
Цусан суулга	36	57	21	158.3
Бусад	173	210	37	121.4

Тайлбар -²-дахин их

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар



ХОЁР. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

2.1 АЖИЛ ХАЙГЧ ИРГЭНИЙ ТОО, боловсролын түвшингээр, жил бүрийн 10 сард

Боловсролын түвшингээр	2017 Х	2018 Х	2019 Х	2020 Х	2020 Х 2017 Х	2020 Х 2019 Х
	хүний тоо				хувь	
ДҮН	1 312	1 016	533	268	20.4	50.3
Үүнээс: Эмэгтэй	902	355	360	152	16.9	42.2
Магистр, доктор	7	1	1	1	14.3	0.0
Дээд боловсролтой	309	170	62	78	25.2	125.8
Тусгай дунд	96	33	12	10	10.4	83.3
Техник мэргэжлийн	106	63	12	21	19.8	175.0
Бүрэн дунд	682	643	395	146	21.4	37.0
Бүрэн бус дунд	80	66	34	8	10.0	23.5
Бага	13	11	4	4	30.8	100.0
Боловсролгүй	19	29	13	0	0.0	0.0

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

2.2 АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, жил бүрийн 10 сард

	Бүртгэлтэй иргэдийн тоо		Ажилд орсон иргэдийн тоо		Шинээр нэмэгдсэн иргэдийн тоо	
	2019 Х	2020 Х	2019 Х	2020 Х	2019 Х	2020 Х
ДҮН	533	268	459	1075	176	2159
Айраг	7	3	2	15	1	54
Алтанширээ	10	3	35	11	1	29
Даланжаргалан	28	22	35	2	0	36
Дэлгэрэх	6	1	5	1	0	13
Иххэт	7	0	2	4	0	10
Мандах	6	1	6	0	0	26
Өргөн	13	5	86	2	1	25
Сайхандулаан	19	3	19	5	3	30
Улаанбадрах	18	1	31	39	4	55
Хатанбулаг	8	5	25	100	0	134
Хөвсгөл	7	3	15	0	4	14
Эрдэнэ	35	17	22	42	2	101
Сайншанд	252	132	94	367	125	913
Замын - Үүд	117	72	82	487	35	719

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



2.3 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, эдийн засгийн салбарын ангилал, 2020 оны 10 сарын эцэст

Салбарын ангилал	2019 I-X	2020 I-X
	Тоо	
Бүгд	516	1486
ХАА, ан агнуур, ойн аж ахуй,загас барилт	37	58
Уул уурхай олборлох аж үйлдвэр	173	30
Боловсруулах үйлдвэрлэл	1	1
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	9	19
Усны хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент	12	59
Барилга	59	253
Бөөний ба жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар		55
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	7	9
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	2	7
Мэдээлэл, холбоо		20
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	8	3
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа		
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа		1
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа		381
Төрийн удирдлага, батлан хамгаалах, үйл ажиллагаа, албан журмын	50	66
Боловсрол	43	39
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ	9	48
Урлаг, үзвэр, тоглоом наадам	1	19
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	105	418
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, өрхийн өөрийн		
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа		

2.4 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ажил, мэргэжлийн ангилал, 2020 оны 10 сарын эцэст

Үзүүлэлт	2019 I-X	2020 I-X
	Тоо	
Бүгд	516	1486
Менежер	10	37
Мэргэжилтэн	60	548
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	71	82
Контор, үйлчилгээний ажилтан	26	206
Худалдаа, үйлчилгээний ажилтан	24	96
ХАА, ой загас агнуурын ажилтан	15	1
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний	54	144
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	70	65
Энгийн ажил мэргэжил	179	231
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	7	76

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



2.5 АЖИЛД ЗУУЧИЛСАН ИРГЭД, ажил, мэргэжлийн ангиллаар жил бүрийн 10 сард

Үзүүлэлт	2019 I-X		2020 I-X	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
	тоо		тоо	
Бүгд	459	177	1075	593
Менежер	8	6	19	5
Мэргэжилтэн	58	44	446	314
Техникч болон туслах дэд/мэргэжилтэн	66	28	53	34
Контор, үйлчилгээний ажилтан	23	21	185	117
Худалдаа, үйлчилгээний ажилтан	20	17	74	47
ХАА, ой загас агнуурын ажилтан	15	5	1	0
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан	37	4	92	28
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	65	4	42	0
Энгийн ажил мэргэжил	161	43	160	47
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	6	5	3	1

2.6 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД ОРСОН ИРГЭН, эдийн засгийн салбарын ангиллаар 2020 оны 10 сард

Салбарын ангилал	Бүгд	Эмэгтэй	Бүгдээс: Ажлын байрны шинж, чанараар		
			Байнга	Улирал	Түр
	тоо				
Бүгд	483	188	182	41	260
ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	4	3	3	1	
Уул уурхай олборлолт	2	1	1	1	
Боловсруулах үйлдвэрлэл	18	12	14		4
Цахилгаан, хий уур агааржуулалтын хангамж	18	5	8	9	1
Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент	31	2	31		
Барилга	119	14	34	28	57
Бөөний ба жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	37	17	18		19
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	4	4		2	2
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	26	19	13		13
Мэдээлэл холбоо	2	1	2		
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1		1		
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0				
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	4	2	4		
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	7	2	2		5
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал	140	58	7		133
Боловсрол	26	19	26		
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	8	5	8		
Урлаг үзвэр тоглоом наадам	5	5	5		
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	31	19	5		26
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй	0				
Олон улсын байгууллагын үйл ажиллагаа	0				

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



ГУРАВ. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

3.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн 10 сард

Үзүүлэлт	2019 I-X	2020 I-X	2020 I-X 2019 I-X
	сая төгрөг		хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого	32 346.0	33 437.9	103.4
Тэтгэврийн даатгалын сан	21 382.1	22 559.1	105.5
Тэтгэмжийн даатгалын сан	2 423.8	2 348.1	96.9
Эрүүл мэндийн даатгалын сан	4 017.8	5 538.0	137.8
ҮОМШӨ*-ний даатгалын сан	3 541.5	2 429.3	68.6
Ажилгүйдлийн даатгалын сан	980.8	563.4	57.4
Нийгмийн даатгалын сангийн зарлага	41 677.0	49 452.9	118.7
Тэтгэврийн даатгалын сан	31 210.8	37 154.7	119.0
Тэтгэмжийн даатгалын сан	2 466.3	2 927.6	118.7
Эрүүл мэндийн даатгалын сан	4 689.1	5 848.8	124.7
ҮОМШӨ*-ний даатгалын сан	2 409.6	2 242.6	93.1
Ажилгүйдлийн даатгалын сан	901.2	1 279.2	141.9

3.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 10 сард

Үзүүлэлт	2019 I-X	2020 I-X	2020 I-X 2019 I-X
	хүн		хувь
1. Нийгмийн даатгалд даатгуулагчид	21 575.0	22 195.0	102.9
Албан журмаар даатгуулагчид	17 661.0	18 189.0	103.0
Аж ахуй нэгж, байгууллага	9 179.0	9 372.0	102.1
Төсөвт байгууллага	8 482.0	8 817.0	103.9
Сайн дураар даатгуулагчид	3 914.0	4 006.0	102.4
2. Тэтгэвэр авагчдын тоо	8 689.0	9 277.0	106.8
Өндөр насны тэтгэвэр	6 226.0	6 783.0	108.9
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	1 307.0	1 378.0	105.4
Тэжээгчээ алдсаны	504.0	485.0	96.2
Цэргийн тэтгэвэр	456.0	483.0	105.9
ҮОМШӨ*-ний	196.0	148.0	75.5
	сая төгрөг		
3. Олгосон тэтгэвэр	28 533.9	51 066.4	179.0
Өндөр насны тэтгэвэр	20 671.9	36 920.0	178.6
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	3 299.0	5 748.4	174.2
Тэжээгчээ алдсаны	1 340.0	2 234.5	166.8
Цэргийн тэтгэвэр	2 577.1	5 291.7	205.3
ҮОМШӨ*-ний	645.9	871.8	135.0

Тайлбар: *-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс



3.3 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сумаар

Сумын нэр	2019 I-X	2020 I-X	2020 I-X 2019 I-X
	сая төгрөг		хувь
ДҮН	32346.0	33437.9	103.4
Айраг	597.0	506.5	84.8
Алтанширээ	209.3	225.5	107.7
Даланжаргалан	1504.5	1258.8	83.7
Дэлгэрэх	243.8	254	104.2
Иххэт	454.5	413.1	90.9
Мандах	274.6	291.9	106.3
Өргөн	1177.0	599.9	51.0
Сайхандулаан	269	259.7	96.5
Улаанбадрах	265.2	303.8	114.6
Хатанбулаг	848.5	688.7	81.2
Хөвсгөл	254.7	266.9	104.8
Эрдэнэ	495.5	551.7	111.3
Сайншанд	17183.5	19068.1	111.0
Зүүнбаян баг	1025.3	931.4	90.8
Замын-Үүд	7543.6	7817.9	103.6

3.4 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, сумаар

Сумын нэр	2019 I-X	2020 I-X	2020 I-X 2019 I-X
	сая төгрөг		хувь
ДҮН	41677.0	49452.9	118.7
Айраг	2063.2	2326.3	112.8
Алтанширээ	783.6	900.9	115.0
Даланжаргалан	1857.7	1972.7	106.2
Дэлгэрэх	870.1	1065.2	122.4
Иххэт	1491.5	1671.3	112.1
Мандах	887	1047.3	118.1
Өргөн	1558.4	1526.0	97.9
Сайхандулаан	598.1	758.3	126.8
Улаанбадрах	937.0	1058.0	112.9
Хатанбулаг	1621.8	1850.3	114.1
Хөвсгөл	764.4	925.1	121.0
Эрдэнэ	1418	1664.8	117.4
Сайншанд	17468.8	21367.9	122.3
Зүүнбаян баг	1553.3	1734.2	111.6
Замын-Үүд	7804.1	9584.6	122.8



3.5 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 10 сарын эцэст

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2020 I-X	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2020 I-X
	2019 I-X	2020 I-X	2019 I-X	2019 I-X	2020 I-X	2019 I-X
	тоо		хувь	сая төгрөг		хувь
НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ	24580	23448	95.4	7008.1	7337.8	104.7
1. Халамжийн тэтгэвэр	1420	1399	98.5	2140.0	3114.1	145.5
Ахмад настны тэтгэвэр	86	102	118.6	119.2	214.5	179.9
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр	1334	1297	97.2	2020.8	2899.6	143.5
2 Нөхцөлт мөнгөн тэтгэмж	1099	1169	106.4	707.3	927.5	131.1
Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэнд олгосон тэтгэмж	1039	1110	106.8	665.3	879.7	20.5
Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгазан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	51	54	105.9	36.0	44.1	122.5
Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг мөн хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	7	5	71.4	4.5	3.7	82.2
Ахмад настаныг гэртээ асрамжилж байгаа иргэн	2	0	0.0	1.5	0.0	0.0
Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн		0		0.0	0.0	
3. Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн дүн	1001	1083	108.2	506.5	762.2	720.5
16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	232	249	107.3	322.4	561.7	174.2
Байнгын асаргаа шаардлагатай 16-с дээш насны иргэн	705	780	110.6	99.3	126.9	127.8
Гурав ба түүнээс дээш тооны бага насны /14 хүртэлх насны/ хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/	0	0	0.0	0.0	0.0	0.0
2 ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж	10	11	110.0	16.0	22.0	137.5



Хүснэгт 3.5-ийн үргэлжлэл

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2020 I-X 2019 I-X	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2020 I-X 2019 I-X
	2019 I-X	2020 I-X		2019 I-X	2020 I-X	
	тоо		хувь	мянган төгрөг	хувь	
18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	7	6	85.7	12.4	7.2	58.1
Гэнэтийн аюул, ослын улмаас орон гэргүй болсон өрх	41	34	82.9	49.2	40.8	82.9
Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн	1	1	100.0	1.2	1.2	100.0
Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай, 4 ба түүнээс дээш 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон иргэн	5	2	40.0	6.0	2.4	40.0
4. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардал	0	0	0.0	0	0	0.0
5. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах зардал	9403	8371	89.0	969.60	1116.2	115.1
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлтийн зарцуулалт	3860	3024	78.3	300.4	320.1	106.6
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	197	309	156.9	87.6	114.2	130.4
Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүн, сум, хорооны нийгмийн ажилтанд олгох урамшил	105	105	100.0	4.9	5.0	102.0
Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт	3682	3766	102.3	370.6	652.6	2.7 ²
Банкны шимтгэл				3.9	4.0	102.6
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжийн зарцуулалт	1559	1167	74.9	202.2	20.3	10.0
6. Бусад халамжийн дүн	11657	11426	98.0	2684.7	1417.8	52.8
Алдарт эхийн одонгийн тусламж	4985	5010	100.5	660.4	638.5	96.7
